



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/568

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж, холбогдох хууль, журамд нийцүүлэн, зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр)-т даалгасугай.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725022706

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
04 дүм сарын 25-ны өдрийн
1568 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	(сая төгрөг) 2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Нарны хорооллоос Нарны зам руу төмөр зам дээгүүр гарсан гүүрэн гарц (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг)	2024	2025	216.8	216.8
ДҮН				216.8	216.8

